



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 06 сарын 14 өдөр

Дугаар A/1424

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.б, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/119 дүгээр тушаалаар батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам”-ын 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл хүсч ирүүлсэн төслүүдийн иж бүрдэл шалгах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журмыг мөрдөж, төсөл ирүүлэгчийн мэдээллийг нууцалж ажиллах, төслийн иж бүрдлийг шалган шаардлага хангасан төслүүдийг 2019 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн дотор дэд хороонд тайлагнахыг ажлын хэсэг (А.Отгонцэцэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100706

Аймгийн Засаг даргын 2019 оны 06
дугаар сарын 11 ны өдрийн 42 дугаар
захирамжийн хавсралт

**ТӨСЛИЙН ИЖ БҮРДЭЛ ШАЛГАХ АЖЛЫН
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: А.Отгонцэцэг- аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Гишүүд: Д.Бямбадулам- аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж
ахуйн газрын мэргэжилтэн
Н.Дулам- аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт
хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

-оОо-